



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 10 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны эхний (гарааны) үлдэгдэл тооцоход баримтлах шимтгэлийн хувь хэмжээ, цалин хөлсний дундаж индекс (итгэлцүүр)-ийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3.7, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, Монгол Улсын Их Хурлын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралтын 2.2.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Нэрийн дансны эхний (гарааны) үлдэгдэл тооцоход баримтлах шимтгэлийн хувь хэмжээг 19 хувиар; үйл ажиллагааны болон тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэрт зарцуулах зардлын хувь хэмжээг 4 хувиар тус тус тогтоосугай.

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр”-ийг тогтоосонтой холбогдуулан “Нэрийн дансны эхний үлдэгдэл тооцоход баримтлах цалин хөлсний дундаж индекс (итгэлцүүр)”-ийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

Гурав. Энэ тогтоолын 1, 2 дахь хэсэгт заасан шимтгэлийн хувь хэмжээ, цалин хөлсний дундаж индекс(итгэлцүүр)-ийг үндэслэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны харилцааг зохицуулах журам, Цалин хөлсний дундаж индекс(итгэлцүүр)-ийг хэрэглэх журмыг 2010 оны I улиралд багтаан шинэчлэн баталж, мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар(Ч.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба(Х.Алимаа)-д даалгасугай.

Тав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 1999 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 06 тоот зөвлөмжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.НЯМХҮҮ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
2 тоот тогтоолын хавсралт

Нэрийн дансны эхний үлдэгдэл тооцоход баримтлах
цалин хөлсний дундаж индекс(итгэлцүүр)

№	Он	Цалин хөлсний дундаж индекс (итгэлцүүр)
1	1995	10,06
2	1996	4,60
3	1997	3,83
4	1998	3,54
5	1999	3,22